



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК

Танилцуулга
2019 оны 10 дугаар сар


Улаанбаатар
2019



1 Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 11.7 хувиар өсч 20.5 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 6.4 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 4.1 нэгж хувийг төгрөгийн харилцах, 2.4 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, -1.2 нэгж хувийг гадаад валютын харилцах бүрдүүлсэн байна.


Зураг 1-1: M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 11.7%-иар нэмэгдсэн байна.



Эх сурвалж: Монголбанк

Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 37.3 тэрбум төгрөг буюу 0.2 хувиар өсчээ.

Зураг 1-2: M2 мөнгө өмнөх сараас 37.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.




Эх сурвалж: Монголбанк

Тодруулбал улс болон хувийн байгууллагын төгрөгийн харилцах, иргэдийн гадаад валютын хадгаламж өсчээ. Харин улсын байгууллагын гадаад валютын харилцах, иргэд болон бусад санхүүгийн байгууллагын төгрөгийн хадгаламж, хувийн байгууллагын төгрөгийн хадгаламж буурсан байна.

Нийт хадгаламжийн хэмжээ 13.8 их наяд төгрөг байгаа ба 85.4 хувь буюу 11.8 их наяд төгрөг нь иргэдийн, 14.6 хувь буюу 2.0 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 23.0 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Үүнээс иргэдийн хадгаламжийн 22.9 хувийг, байгууллагын хадгаламжийн 23.3 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

Зураг 1-3: Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 7.9%-иар өсч 13.8 их наяд ₮-т хүрчээ.




Эх сурвалж: Монголбанк

M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 17.7 их наяд төгрөг,

гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 2.7 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал М2 мөнгөний өсөлтийн 14.3 нэгж хувийг ГЦА, -2.6 нэгж хувийг ДЦА бүрдүүлж байна. ГЦА-ын өсөлтөнд Төв банкны гадаад цэвэр актив нэмэгдсэн нь нөлөөлсөн байгаа бол ДЦА буурсан нь Төв банкнаас Засгийн газарт өгөх өглөг нэмэгдсэн болон банкуудын зээл олголт буурсантай холбоотой байна.

Зураг 1-4: М2 мөнгөний жилийн өсөлтийн дийлэнх хэсгийг ГЦА-ын өсөлт бүрдүүлж байна.



Эх сурвалж: Монголбанк

2 Банкуудын зээл

2.1 Зээлийн өсөлт

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар өсч 18.0 их наяд төгрөгт хүрсэн байна. Үүнээс иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 12.5 хувиар өсч 9.3 их наяд төгрөгт, хувийн байгууллагын зээл 8.2 хувиар өсч 8.5 их наяд төгрөгт хүрчээ.

Зураг 2-1: Нийт зээлийн үлдэгдэл 18.0 их наяд төгрөгт хүрч жилийн 10.6 хувиар өсөв.




Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн үлдэгдлийн 12.2 хувь буюу 2.2 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний валютын зээл байна.

2.2 Зээл олголт, эргэн төлөлт

Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 169.9 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 212.8 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

Зураг 2-2: Тайлант сард 2,018 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 1,977 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдлөө.




Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон зээлийн 14.2 хувь буюу 285.6 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

2.3 Чанаргүй зээл

Чанаргүй зээлийн 81.9 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 77.5 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлжээ.

Зураг 2-3: Чанаргүй зээл нь нийт зээлийн 10.7%, хугацаа хэтэрсэн зээлийн 5.2%-тай тэнцэж байна.



Тайлбар: * үйл ажиллагаа явуулж буй 13 банкаар
Эх сурвалж: Монголбанк

Чанаргүй зээлийн үлдэгдэл 1,922.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 43.9 тэрбум төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээлийн 17.6 хувь нь гадаад валютаар олгогджээ.

Чанаргүй зээлийн 23.0 хувийг уул уурхай, 21.0 хувийг боловсруулах, 12.0 хувийг барилга, 8.5 хувийг худалдааны салбарын зээл эзэлж байна.

Зураг 2-4: Чанаргүй зээлийн 81.9% хувийн байгууллагын, 17.1% иргэдийн зээл байна.




Эх сурвалж: Монголбанк

2.4 Хувийн байгууллагын зээл

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл тайлант сард өмнөх сараас 4.3 тэрбум төгрөгөөр өсчээ.

Зураг 2-5: Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, боловсруулах болон уул уурхайн салбарын зээл бүрдүүлэв.



Эх сурвалж: Монголбанк

Хувийн байгууллагын зээлийн өөрчлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилан харуулбал уул уурхайн салбарын зээл

78 тэрбум, боловсруулах салбарын зээл 26.5 тэрбум, худалдааны салбарын зээл 19.9 тэрбум төгрөгөөр тус тус өсч, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын зээл 76 тэрбум, тээврийн үйл ажиллагааны салбарын зээл 26.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Тайлант сард хувийн байгууллагад 1,074.0 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 24.5 хувь буюу 263.0 тэрбум төгрөгтэй тэнцэх зээл гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-6: Худалдаа, уул уурхай, боловсруулах салбарт дийлэнх зээл олгогдсон байна.




*Цахилгаан хий, усан хангамж, газар тариалан, мэдээлэл холбоо, санхүү даатгал, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд.

Эх сурвалж: Монголбанк

2.5 Иргэдийн зээл

Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 21.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 2-7: Иргэдийн зээлийн 37% (МИК-д ишлжүүлсэн багцыг оруулснаар)-ийг орон сууцны зээл, 33%-ийг цалин тэтгэврийн зээл бүрдүүлэв.




Эх сурвалж: Монголбанк

Үүнээс, ипотекийн зээл 21.1 тэрбум, хадгаламж барьцаалсан зээл 20.4 тэрбум, худалдааны зээл 7.4 тэрбум төгрөгөөр өссөн, харин цалин, тэтгэврийн зээлийн үлдэгдэл 49.8 тэрбум, автомашины зээл 8.7 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Тайлант сард иргэдэд 889.0 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 2.5 хувь буюу 21.9 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-8: Хадгаламж барьцаалсан, цалин тэтгэвэр, картын зээл ихэнх хувийг эзэлж байна.




*ХАА, газар тариалан, боловсруулах, цахилгаан хий, усан хангамж, тээвэр агуулах, үйлчилгээ, мэдээлэл холбоо, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд.
Эх сурвалж: Монголбанк

2.6 ЖДҮ-ийн зээл

ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 4,069 тэрбум төгрөгт хүрчээ.

Зураг 2-9: ЖДҮ эрхлэх зориулалтаар ААН болон иргэдэд олгосон зээлийн 32 хувийг салбар бүрдүүлж байна.




Эх сурвалж: Монголбанк

Үүний 32.3 хувийг худалдааны салбарт, 14.8 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 13.3 хувийг барилгын салбарт, 8.2 хувийг үйлчилгээний салбарт тус тус олгосон байна.

3 Ипотекийн зээл

2019 оны 10 дугаар сарын байдлаар 95,490 зээлдэгч нийт 4.6 их наяд төгрөгийн ипотекийн зээлтэй байна. Үүнээс хөтөлбөрийн эх үүсвэрээр 71,073 зээлдэгч 3.4 их наяд төгрөгийн зээл авчээ.

Зураг 3-1: Ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 4.5%-д хүрэв.




Эх сурвалж: Монголбанк

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 74.1 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 20.6 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 5.3 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна. Нийт ипотекийн зээлийн 16.9 хувь буюу 768 тэрбум төгрөгийн зээл орон нутагт ногдож байна. Орон

нутгийн ипотекийн зээл¹-ийн 78 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 19 хувь нь банкны өөрийн эх үүсвэрээр, 3 хувь нь бусад эх үүсвэрээр олгогдсон байна.

Зураг 3-2: Нийт зээлийн 16.9% буюу 768 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.



Эх сурвалж: Монголбанк

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.5 хувь нь хэвийн, 2.5 хувь нь хугацаа хэтэрсэн, 2.0 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 60.4 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 37.9 хувийг хөтөлбөрийн зээл, 1.7 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

Зураг 3-3: Өмнөх сараас хугацаа хэтэрсэн зээл 6.0 тэрбум төгрөгөөр буурч, чанаргүй зээл 0.7 тэрбум төгрөгөөр өсчээ.



Эх сурвалж: Монголбанк

Тайлант сард 944 зээлдэгчид 71.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосон бөгөөд үүний 36.7% хувийг хөтөлбөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.


Зураг 3-4: Тайлант сард шинээр 944 зээлдэгчид ипотекийн зээл шинээр олгожээ.



Эх сурвалж: Монголбанк

Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурч 12.6 хувьд хүрсэн байна.

Зураг 3-5: Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурчээ.



Эх сурвалж: Монголбанк


¹ Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

4 Хүү

4.1 Шинээр татсан хадгаламж


2019 оны 10 дугаар сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 11.1 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 4.2 хувьтай байна.

Зураг 4-1: Шинээр татсан хадгаламжийн хүү 0.6 нэгж хувиар буурав.



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4-2: Шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүү 11.5%, хугацаагүй хадгаламжийн хүү 6.5% байна.



Эх сурвалж: Монголбанк


4.2 Шинээр олгосон зээл

Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 16.8² хувь, гадаад валютын ЖДХ 8.9 хувьд хүрч

² Хөтөлбөрийн зээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.


өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж, 1.1 нэгж хувиар тус тус буурав.

Зураг 4-3: Шинээр олгосон зээлийн хүү 16.8% байна.



Эх сурвалж: Монголбанк

Зураг 4-4: Шинээр олгосон нийт зээлийн хүү өмнөх оноос 0.8 нэгж хувиар буурав.



Эх сурвалж: Монголбанк


Иргэдэд 888.9 тэрбум төгрөгийн зээл олгосноос дийлэнх нь буюу 73.4 хувь нь 2 жил хүртэлх хугацаатай байна.

4.3 Үлдэгдлээрх хадгаламж

Нийт төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ 11.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар буурчээ. Харин нийт гадаад валютын хадгаламжийн ЖДХ 4.8 хувьтай байна. Хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ иргэдийн төгрөгийн хадгаламжийн

хувьд 11.6 хувь, гадаад валютын хадгаламжийн хувьд 4.8 хувьтай байгаа бол хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн хувьд 11.1 хувьтай байна.

Зураг 4-5: Үлдэгдлээр жигнэсэн хадгаламжийн хүү 11.5% байна.




Эх сурвалж: Монголбанк

4.4 Хүүний зөрүү

Тухайн сард шинээр олгосон төгрөгийн зээл болон тухайн сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүүний зөрүү 2019 оны 10 дугаар сарын байдлаар 5.7 нэгж хувьд хүрэв.

Зураг 4-6: Хадгаламж, зээлийн хүүний зөрүү өмнөх оноос 0.1 нэгж хувиар буурчээ.




Эх сурвалж: Монголбанк

4.5 Зээлийн үлдэгдэл

Төгрөгийн зээлийн үлдэгдэлд ЖДХ 16.9 хувь, гадаад валютын зээлийн

ЖДХ 10.6 хувьтай байна. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 17.8³ хувьтай, гадаад валютын зээлийн ЖДХ 12.7 хувьтай байна. Хувийн байгууллагын зээлийн ЖДХ 15.6 хувьтай, гадаад валютын зээлийн хүү 10.6 хувьтай байна. Нийт төгрөгийн зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Зураг 4-7: Иргэдийн зээлийн үлдэгдэлд жигнэсэн хүү 0.7 нэгж хувиар буурав.



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн үлдэгдлийн дийлэнхийг 25-36 болон 37-60 сарын хооронд төлөгдөж дуусах зээлүүд эзэлж байна.

Зураг 4-8: Зээлийн үлдэгдэл, хугацаагаар



Эх сурвалж: Монголбанк

³ Хөтөлбөрийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.

5 Инфляци

5.1 Улсын инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс 2019 оны 10 дугаар сарын байдлаар жилийн 7.6 хувь, сарын инфляци -0.3 хувь байна.

Зураг 5-1: Улсын жилийн инфляци 7.6 хувьтай байна.



Эх сурвалж: УСХ

Жилийн инфляцийг авч үзвэл хүнсний барааны үнийн өсөлт мах болон хүнсний ногооны үнийн өсөлтөөр тодорхойлогдож байгаа бол хүнснээс бусад барааны өсөлтөд хувцас, бөс бараа болон орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлт нөлөөлсөн байна.

5.2 Улаанбаатар хотын жилийн инфляци

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 10 дугаар сарын байдлаар 8.5 байгаа ба 4.5 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 4.0 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна.

Хүнснээс бусад барааны үнэд хувцас, орон сууцны урсгал засвартай холбоотой бараа, үйлчилгээ, хатуу түлшний үнийн өсөлт, хүнсний барааны бүлгийн үнэд махны үнийн өсөлт голлон нөлөөлжээ.

Өмнөх сартай харьцуулахад УБ хотын хэмжээнд 0.6 хувийн дефляцитай

байна. Үүний 0.56 нэгж хувийг хүнсний бараа, 0.06 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн бууралтаар тайлбарлагдаж байна.


Зураг 5-2: УБ хотын жилийн инфляци 8.5 хувь



Эх сурвалж: УСХ

Хүнснээс бусад барааны үнэ буурахад голлон агаарын зорчигч тээврийн үйлчилгээний үнийн бууралт нөлөөлжээ. Харин хүнсний барааны үнэ буурахад хүнсний мах болон ногооны үнийн бууралт нөлөөлжээ.

Зураг 5-3: УБ хотын сарын инфляци дефляцитай байна.




Эх сурвалж: УСХ

6 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

6.1 Ам.долларын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сарын эцсийн байдлаар 2,701.2 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 1.3 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2,678.0 төгрөг байв.

Зураг 6-1: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт.




Эх сурвалж: Монголбанк

6.2 Хятадын юанийн ханш

Төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш өмнөх сараас суларч 384.0 төгрөг байв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 373.1 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 384.0 төгрөг байлаа.

Зураг 6-2: Төгрөгийн юаньтай харьцах ханшийн өөрчлөлт.




Эх сурвалж: Монголбанк


ХАВСРАЛТ

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. М2 Мөнгөний сарын өсөлтийн бүтэц




Зураг 1.2. Нөөц мөнгөний бүтэц



2. ЗЭЭЛ

Зураг 2.1. Зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт




Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /сектороор/




Зураг 2.3. Иргэдийн зээлийн жилийн өсөлтийн задаргаа /зээлийн төрлөөр/




Зураг 2.4. Хувийн байгууллагын зээлийн жилийн өсөлтийн задаргаа /салбараар/




Зураг 2.5. Тайланд сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл



Зураг 2.6. Тайлант сард шинээр олгосон зээл (салбараар)




Зураг 2.7. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл



Зураг 2.8. Чанаргүй зээлийн дүн



Зураг 2.9. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл




Зураг 2.10. ЖДҮ-ийн зээл дэх чанаргүй зээлийн хувь, салбараар




Зураг 2.11. Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц




Зураг 2.12. Орон нутагт шинээр олгосон, төлөгдсөн зээл



Зураг 2.13. Орон нутгийн зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/



Зураг 2.14. Орон нутгийн чанаргүй зээлийн эзлэх хувь




3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


Зураг 3.1. Тухайн сард олгосон ипотекийн зээл, санхүүжилтийн эх үүсвэрээр




Зураг 3.2. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар




Зураг 3.3. Тухайн сард нийслэл хотод олгогдсон ипотекийн зээл, орон сууцны байршлаар




Зураг 3.4. Орон нутгийн ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар




Зураг 3.5. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он




Зураг 3.6. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Зураг 3.7. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт




Зураг 3.8. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл




4. ХҮҮ

Зураг 4.1. Хугацаагүй хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалт



Зураг 4.2. Хугацаатай хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалт



Зураг 4.3. Нийт зээлийн үлдэгдлийн хүүний тархалт

